

## МОНГОЛ УЛС БОЛОН ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

### COMPARING IMPRISONMENT IN RUSSIA AND MONGOLIA THEIR TENDENCY



#### Ц.ОЧГЭРЭЛ

ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, докторант, хурандаа

#### OCHGEREL TS.

Dean of Court Decision Execution studies center, Research and Development institute, Law Enforcement University, Ph.D student, Colonel

**Товч агуулга:** Энэхүү өгүүлэгээр Оросын Холбооны Улс болон Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлог талуудыг харьцуулан үзэхийн зэрэгцээ хорих ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар санал дэвшүүлэх зорилтыг тавьсан.

**Abstract:** This researching work aims to compare the specificity of the imprisonment of Russia and Mongolia. In addition, it will be proposed to improve the legal regulation and imprisonment system and the effectiveness of imprisonment.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой үр нөлөөтэй, олон сонголттой болгох» зорилтыг дэвшүүлсэн.<sup>1</sup> Энэхүү зорилтын хүрээнд Хууль зүйн яамнаас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчлийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулан УИХ-д өргөн бариад байгаа билээ.<sup>2</sup>

Шинээр боловсруулагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ялын төрлийг өөрчлөн хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх замаар хорих ял шийтгэгдэх, эдлэх явдлыг багасгах бодлого тусгагдсан энэ цаг үед хорих ял эдлүүлэх ажиллагааг ялын зорилго, нийгмийн хөгжилтэй уялдуулан шинэчлэх шаардлага бий болж байна. Иймээс миний бие Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, ялтныг нийгэмшүүлэх (засан хүмүүжүүлэх) зорилтыг дэвшүүлэн хорих ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийн үзэл баримтлал боловсруулан баталсан ОХУ-ын ял эдлүүлэх ажиллагаатай харьцуулан үзэж, чиг хандлагын талаар өөрийн саналыг дэвшүүлэхийг зорилоо.

<sup>1</sup> Төрийн мэдээлэл. 2012 он. № .<http://www.legalinfo.mn/annex/details/5591?lawid=8722>

<sup>2</sup> [http://moj.gov.mn/draft\\_law.html](http://moj.gov.mn/draft_law.html)


### Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар

Монгол Улсад хорих ял эдэлж байгаа хүний тоог хүн амын тоон үзүүлэлттэй харьцуулж авч үзвэл дэлхийн бусад орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлттэй буюу 100.000 хүн ам тутамд 220 орчим ялтан ноогдож байна. Хорих ял эдлэгсдийн тоо өссөн, хорих газраас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй байгаа зэрэг нь ял эдлүүлэх ажиллагааны талаар баримтлах бодлогыг шинэчлэх шаардлагыг бий болгож байна.

Хорих ангиас суллагдсан хүн нийгмийн харилцаанд оролцох чадваргүйн улмаас дахин гэмт хэрэг үйлдэж, улмаар “шоронжсон” буюу гэмт хэрэг үйлдэн хорих ялаар удаа дараа шийтгүүлэх амьдралын хэв маяг бүхий хүмүүсийн тоо өсөх хандлагатай байна. Дэлхийн бусад улс орнуудын жишигээс авч үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагаа нь зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолын хүрээнд нийгмээс тусгаарлах бус суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд дасан зохицох чадвар суулгах буюу нийгэмшүүлэхэд гол анхаарлаа хандуулж байна.

Монгол Улсад Хорих байгууллага үүсч байгуулагдсан 1921 оноос эхлэн өнөөдрийг хүртэлхи хугацаанд хорих газрын төрөл дэглэм буюу хорих орчин, дотоод дэглэм журам, ял эдлүүлэх ажиллагааны зохион байгуулалтыг харилцан адилгүй байдлаар тогтоон мөрдөж иржээ. Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулинд туссан ял эдлүүлэх нөхцөл, ялтны эрхийн хязгаарлалтын асуудлууд нь 1966 онд батлагдсан “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн тухай хууль”-нд анх тусгалаа олсоноос хойш дараачийн хуулиудад /1981, 1993, 1996, 2002/ уламжлагдан батлагдсаар өнөөдрийг хүрсэн байдаг<sup>3</sup>.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 25 хорих ангид 6500 орчим ялтан ял эдэлж байна. Үүнээс гяндан буюу хорих ерөөний системтэй, хөдөлгөөний хатуу хязгаарлалт бүхий хорих ангид 70-90 ялтан, онцгой дэглэмд буюу хөдөлмөрлөх цаг, бусад эрхийн хязгаарлалт өндөр бүхий хорих ангид 300 орчим, чанга дэглэмд 2600-2700, жирийн дэглэм бүхий хорих ангид 3400 орчим, баривчлах ял эдлүүлэх ангид 170 орчим ялтан ял эдэлж байна. Үүнээс эмэгтэйчүүдийн хорих ангид 350 орчим ялтан, насанд хүрээгүйчүүдийн хорих 30 орчим ялтан ял эдэлж байна.<sup>4</sup>



<sup>3</sup> А.Лхагва. “МУ-ын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй” Улаанбаатар 2012 он. 42-70 дах тал.


<sup>4</sup> ШШГЕГ-ын 2015 оны 3 дугаар сарын албаны статистик мэдээнээс...

1-р зураг. Хорих ял эдлэгсдийн тоон үзүүлэлт

Нийт ял эдлэгсдийн дунд урьд нь гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдэж байсан ялтны эзлэх хувийг судалж үзэхэд нийт ялтны дунд эзлэх хувь нь 51-54%, харин чанга буюу түүнээс дээш дэглэмийн хорих ангид ял эдлэгсэдийн 85 орчим хувь нь урьд нь хорих ялаар 1-8 удаа шийтгэгдэж байсан тоон үзүүлэлт гарч байна.

Өнөөдрийн нөхцөл байдлаас үзвэл хорих ангийн төрөл, дэглэмийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, нийгмийн хөгжлийн зорилт, олон улсын жишигтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлага тулгарч байгаа ба хатуу буюу уян хатан бус нөхцөл, хязгаарлалттай дэглэмд хорих нь ялтныг аажмаар шоронжих замаар гэмт аргаар амьдрах зам руу хөтөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2013-2014 онуудад бүх төрлийн дэглэмийн хорих ангийг хамруулан хэсэгчилсэн судалгаа хийж үзэхэд боловсролын ямар нэг түвшинд суралцаж байгаагүй ялтан 6%, бүрэн дунд, бүрэн боловсролын сургалтанд хамрагдсан буюу хагас хамрагдсан ялтан 81%, бакалаврын сургалтанд хамрагдсан ялтан 13%, мэргэжилгүй ялтан 69%, мэргэжлийн ямар нэг сургалтанд хамрагдсан ялтан 22%, хорих ангид ял эдэлж байхдаа мэргэжлийн сургалтанд хамрагдсан ялтан 9% байсан байна.



2-р зураг. Хорих ял эдлэгсдийн боловсрол, мэргэжлийн судалгаа /бүх төрлийн дэглэмийн хорих ангийг хамруулан 1000 ялтнаар хэсэгчилэн авав/.

Дээрх судалгаанаас үзвэл хорих ял эдлэгсэдийн хувьд нийгмийн тодорхой байр суурьгүй, ажил эрхлэлт муу, тодорхой орлогын эх үүсвэргүй, боловсролын түвшин хангалтгүй, суллагдаад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцох чадваргүйгээр дахин гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдэж байгаа дүгнэлт гарч байна. Өөрөөр хэлбэл ялын бодлогод дорвитой өөрчлөлт хийхийн зэрэгцээ хорих байгууллагын тогтолцоо, ял эдлүүлэх ажиллагаа ба түүний эрх зүйн зохицуулалтыг хүн ба нийгмийн хөгжилийн дэмжихэд чиглэсэн байдлаар өөрчлөх шаардлага бий болсоныг харуулж байна.

Одоогийн мөрдөгдөж буй хуулиар хорих ял эдлүүлэх байгууллагын төрөл, дэглэм хоорондын ялгаа төдийлөн оновчтой биш, ялтны эргэлт уулзалтын давтамж, захидал харилцаа, илгээмжийн тоон хязгаарлалт, ажлын цаг, хоолны илчлэгийн зөрүү, хамгаалалтын бүс, түүнд ашиглагдаж буй техник хэрэгсэл зэрэг үзүүлэлтээр жирийн дэглэмээс онцгой дэглэм рүү нөхцөлийг хүндрүүлэх шинж чанартайгаар зохицуулсан байдаг. Нийгэм, хүний хөгжлийг дэмжсэн тогтолцооны өөрчлөлт эрчимтэй хийгдэж буй өнөө цагт гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ял шийтгэгдсэн этгээдийг чухам ямар нөхцөлд ялыг эдлүүлэх, тэр нь өнөөгийн дэлхийн улс орнуудад хэрэгжиж буй дэвшилтэт тогтолцоотой хэрхэн нийцэж

байгааг сайтар судлан үзэх шаардлагатай байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаан дах нийгэмшүүлэх ажлын салшгүй хэсгүүд нь ялтныг сургах болон хөдөлмөрлүүлэх явдал юм.<sup>5</sup> Өнөөдрийн байдлаар нийт хорих ангийн хэмжээнд ялтныг улирлын чанартай 7-9 чиглэлд /газар тариалан, уул уурхай, аж ахуйн нэгж байгууллагад гэрээгээр, барилга, үйлдвэрлэл г,м/ ажиллуулж байгаа хэдий боловч энэ ажлын байранд ажиллаж байгаа ялтны тоо нь нийт ял эдлэгсдийн 35-40 хувиас хэтрэхгүй байна.<sup>6</sup> Түүнчлэн ялтныг мэргэжлийн болон бусад түвшний боловсролд заавал хамруулдаг байх тогтолцоог эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийх нь тэдгээрийг нийгэмшүүлэх улмаар дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

Иймд хорих ял эдэлж буй дэглэмийг тухайн ялтныг нийгэмших, хөдөлмөрлөх, өөрийгөө нээн хөгжүүлэх боломжийг олгосон, суллагдсаны дараа нийгмийн идэвхитэй, хууль ёсыг сахин биелүүлэгч иргэн болгон төлөвшүүлэх шаардлага хангасан байдлаар өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад ялын зорилгыг хангах, түүнчлэн ял эдлүүлэх ажиллагааг нийгмийн хөгжлийг дэмжих, нийгэм дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бодит үр нөлөө үзүүлэхүйц хэлбэрт шилжүүлэх үндсэн нөхцөл нь ялтныг сургах, хөдөлмөрлүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг барагдуулах, сэтгэл засал, нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх, суллагдахад бэлтгэх гэх мэт олон талт үйл ажиллагаагаар дамжин хэрэгжинэ.<sup>7</sup>

ХБНГУ, Польш, Чех, Эстони, Латви зэрэг Европын холбооны гишүүн орнуудын ял эдлүүлэх тогтолцооны шинэчлэлээс судалж үзвэл хорих ял эдлүүлэх дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх замаар хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх асуудлыг оновчтой шийдвэрлэж байна. Дээрх улс орнуудад хэрэгжиж буй хорих ангийн нээлттэй болон хаалттай дэглэмийн гол агуулга нь ялтныг сургах, байнгын тасралтгүй ажлын байраар хангах, ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан стандартын дагуу бүрдүүлэх зэрэг асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэж, хорих ял эдэлж буй хүмүүсийг нийгэмшүүлэхэд чиглэгддэг.

Хорих ял шийтгэгдсэн этгээдийн ялыг нээлттэй, хаалттай дэглэмийн алинд нь эдлүүлэхийг 3-6 сарын хугацаанд тодорхой үе шаттайгаар судалсны дараа тусгайлан томилогдсон мэргэжлийн зөвлөл дамжин өнгөрүүлэх газарт буюу цагдан хорих байрны дэргэдэх хэсэгт ажиллаж шийдвэрлэдэг. Ингэхдээ ялтан тус бүр дээр хэлэлцэж, ял эдлэх хугацаанд хамрагдах сургалтын болон хөдөлмөрлөх чиглэл, тухайн ялтантай ажиллах төлөвлөгөөг нэг бүрчлэн баталдаг нь нийгэмшүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байна.

### **ОХУ-ын хорих ял эдлүүлэх ажиллагааны талаар**

Монгол Улстай хөрш зэргэлдээ орших ОХУ-д эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог хөгжүүлэх замаар ялын зорилгыг хангах, улмаар хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудалд анхаарал хандуулан тодорхой алхмуудыг хийсээр байна.

ОХУ-ын эрүүгийн хууль тогтоомжид зааснаар хорих ял нь хугацааны хувьд хоёр сараас хорин жил хүртэл байхаар хуульчилсан байдаг<sup>8</sup>.

ОХУ-ын эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар эрүүгийн ялын зорилго

<sup>5</sup> А.Лхагва. "МУ-ын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй" Улаанбаатар 2012 он. 229, 257 дах тал

<sup>6</sup> ШШГЕГ-ын 2014 оны үйл ажиллагааны тайлангаас...

<sup>7</sup> С.Жанцан "МУ-ын Эрүүгийн эрх зүйн онол" Улаанбаатар 2014 он. 138-139 дэх тал.

<sup>8</sup> Кодексы Российской Федерации. Официальный текст. Уголовный кодекс. Москва 2014 г, с.26

болон ял эдлүүлэх ажиллагаа түүнийг зохицуулж буй хууль тогтоомжийн зорилгыг харилцан уялдаа холбоотой, нэгдмэл нэг ойлголт болгон авч үзсэн байдаг. “Хэрэв ялын зорилго болон эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомжийн зорилгыг харьцуулж үзвэл бүхэлдээ утга санаа давхцаж байна. Энэ тохиолдолд эрүүгийн хууль тогтоомжийн үндсэн ойлголтууд нь эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн зорилготой харилцан уялдаа холбоо бүхий нэгдсэн ойлголт юм”<sup>9</sup>. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар “Эрүүгийн ял эдлүүлэх хууль тогтоомийн зорилго нь ялтан болон бусад этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ялтныг засан хүмүүжүүлэх явдал юм”<sup>10</sup>, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 43 дугаар зүйлд “Ялыг нийгэмд шударга ёсыг сэргээн тогтоох, ялтныг засан хүмүүжүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэнэ” гэж тус тус заажээ.

д/д	Харьцуулах чиглэл	ОХУ	Монгол Улс
1.	Эрүүгийн ялын /хариуцлагын/ зорилго	Нийгэмд шударга ёсыг сэргээн тогтоох, ялтныг засан хүмүүжүүлэх болон дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх <sup>1</sup>	Иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх <sup>2</sup>
2.	Эрүүгийн ялын төрөл	Торгох; Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; Төрийн шагнал, тусгай, хүндэт, цэргийн цол зэргийг хураах; Заавал гүйцэтгэх ажил хийлгэх; Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх; Цэргийн алба хаахыг хязгаарлах; Эрх чөлөөг хязгаарлах; Албадан ажил хийлгэх; Баривчлах; Цэргийн сахилгын хэсэгт хорих; Тодорхой хугацаагаар хорих; Бүх насаар хорих; Цаазаар авах; <sup>3</sup>	Торгох.; Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах; Эд хөрөнгө хураах; Албадан ажил хийлгэх; Баривчлах; Хорих; Цаазаар авах. <sup>4</sup>
3.	Хорих ялын хугацаа	2 сараас 20 жил	1 жилээс 25 жил

<sup>9</sup> МГУ им. М.В.Ломоносова “Уголовно-исполнительное право России” Москва 2013 г, с.46

<sup>10</sup> Кодексы Российской Федерации. Официальный текст. Уголовно-исполнительный кодекс. Москва 2007 г, с.3

4.	Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцооны хөгжлийн үзэл баримтлал	ОХУ-ын ЗГ-ын 2010.10.14-ны 1772 дугаар тогтоол "ОХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал"	Хөгжлийн үзэл баримтлал байхгүй МУ-ын ЗГ-ын 2012.0.05-ны 193 дугаар тогтоол "Хорих ангийн төрөл дэглэмийг нээлттэй хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр"
5.	100.000 хүн ам тутамд ноогдох ялтны тоо	ОХУ-ын нийт хүн амын тоо: -146.270.033 <sup>5</sup> /МУ-ын хүн амаас 58 дахин их/ 100.000 хүн ам тутамд ноогдох ялтны тоо: - 459	МУ-ын нийт хүн амын тоо: -3.000.000 100.000 хүн ам тутамд ноогдох ялтны тоо: 217

### 3-р зураг. Ялын бодлогын чиглэлээрх харьцуулалт

ОХУ-ын хорих ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялтныг засан хүмүүжүүлэх, болон тэдгээрийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү зорилгын агуулгаас улбаалан хорих ял эдүүлэх байгууллагын төрөл, үйл ажиллагааны чиглэлийг хууль тогтоомжиндоо заасан байдаг. Өөрөөр хэлбэл хуулийн санаа нь ял эдлүүлэх ажиллагааны гол агуулгыг гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн этгээдийг засан хүмүүжүүлэх буюу ялтныг тодорхой арга хэлбэрийг ашиглан хуулийг сахин биелүүлдэг, нийгмийн харилцаанд оролцохдоо бусдын эрх ашгийг дээдлэн хүндэтгэдэг зөв иргэн болгон төлөвшүүлэхэд чиглүүлдэг хэмээн үзэж болох юм.

ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 9 дүгээр зүйлд засан хүмүүжүүлэх ажил гэдгийг "...ялтныг хүн, нийгэм, хөдөлмөр, хүн төрөлхтний аж төрөх ёсны хэм хэмжээ, зан заншил, журмыг хүндэтгэсэн харилцаанд оруулах, хууль сахин биелүүлэх зан үйлийг дэмжин урамшуулах ажиллагааны бүрдэл", засан хүмүүжүүлэх ажлын арга, хэлбэрийг "...ял эдлүүлэх дэглэм журмыг тогтоох, хүмүүжлийн ажил, нийгэмд тустай хөдөлмөр, ерөнхий боловсрол олгох, мэргжлийн сургалт, нийгмийн нөлөөлөл үзүүлэх"<sup>11</sup> гэж тодорхойлсон байна. Ял шийтгэгдсэн хүнийг гэмт зан үйлээс татгалзуулах, хөдөлмөр болон сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг тухайн хүнийг хүмүүжүүлэхэд чиглүүлдэг байна.

Дээрх хорих газруудаас гадна ОХУ-ын ял эдлүүлэх тогтолцоонд байдаг бас нэг хэлбэр нь эмчилгээний засан хүмүүжүүлэх газар /лечебные исправительные учреждения/ бөгөөд энэ газарт мансуурах, согтуурах донтой, ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, бусад эмчилгээ шаардлагатай ялтныг байлгаж ял эдлүүлдэг. Эцэст нь хүмүүжлийн хорих газар /воспитательные колонии/-т насанд хүрээгүй болон 19 нас хүртэл уг газарт үлдсэн ялтны ялыг эдлүүлдэг. Цагдан хорих байр нь засан хүмүүжүүлэх газрын чиг үүргийг хэрэгжүүлдэг хэд хэдэн тохиолдол байдаг ба энэ нь аж ахуй, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болохыг хүлээх, өөр хорих газарт шилжүүлэх үед, б сараас ихгүй хугацаагаар ял шийтгэгдсэн ялтныг өөрийн зөвшөөрсөнөөр цагдан хорих байранд байлгах хуулийн зохицуулалтай байдаг.

<sup>11</sup> Кодексы Российской Федерации. Официальный текст. Уголовно-исполнительный кодекс. Москва 2007 г, с.5

д/д	Харьцуулах чиглэл	ОХУ	Монгол Улс
1.	Хорих ял эдлүүлэх ажиллагааны /хууль тогтоомжийн/ зорилго	Ялтан болон бусад этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ялтныг засан хүмүүжүүлэх	Ял эдлүүлэх ажиллагааны зорилго хуульчлагдаагүй
2.	Хорих ял эдлүүлэх байгууллаагын төрөл	Засан хүмүүжүүлэх газар /исправительные колонии/, Хүмүүжлийн хорих газар /воспитательные колонии/, Гяндан /тюрьма/, Эмчилгээний засан хүмүүжүүлэх газар /лечебные исправительные учреждения	Баривчлах байр, Насанд хүрээгүй чүүдийн хорих анги, Насанд хүрэгсдийн хорих анги, Эмэгтэйчүүдийн хорих анги, Дамжин өнгөрүүлэх анги, ТГГ-ын нэгдсэн эмнэлэг Гяндан.
3.	Хорих ял эдлүүлэх дэглэм	Засан хүмүүжүүлэх газар /исправительные колонии/ насанд хүрсэн ялтны эрхийг хязгаарладаг бөгөөд дэглэмээр: Суурин хэлбэрээр хорих газар /колония поселения/, Жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения общего режима/, Чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения строгого режима/, Онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх газар /исправительные учреждения особого режима/	Жирийн, Чанга, Онцгой дэглэмийн хорих анги.
4.	Нийгэмшүүлэх ажлын зорилго, хэлбэр	Зорилго нь ялтныг хүн, нийгэм, хөдөлмөр, хүн төрөлхтний аж төрөх ёсны хэм хэмжээ, зан заншил, журмыг хүндэтгэсэн харилцаанд оруулах, хууль сахин биелүүлэх зан үйлийг дэмжин урамшуулах ажиллагааны бүрдэл, Засан хүмүүжүүлэх ажлын арга, хэлбэр: "...ял эдлүүлэх дэглэм журмыг тогтоох, хүмүүжлийн ажил, нийгэмд тустай хөдөлмөр, ерөнхий боловсрол олгох, мэргэжлийн сургалт, нийгмийн нөлөөлөл үзүүлэх" <sup>6</sup>	Ялтныг нийгэмшүүлэх ажлын зорилго хуульчлагдаагүй. Хүсүүжлийн ажлын хэлбэр нь: Ялтныг эрх зүйн мэдээллээр хангах, хөдөлмөрийн дадлага, мэргэжлийн баримжаа олгох, мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ардын уламжлалт зан үйлд сургах
5.	Суллагдсан дараах нийгмийн амьралд дасгах төв бий эсэх	ОХУ-ын ЗГ-ын 2008.11.17-ны 1662 дугаар тогтоол. "ОХУ-ыг 2020 он хүртэл хөгжүүлэх нийгэм-эдийн засгийн урт хугацааны үзэл баримтлал" 8 дугаар бүлэгт <sup>7</sup> "Хорих газраас суллагдсан хүмүүст нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх алба байгуулахаар заасан" Туршилтаар хийж эхэлсэн	Одоогоор хуульчлагдаагүй, төрийн институт байхгүй.

4-р зураг. Хорих ял эдлүүлэх ажиллагааны харьцуулалт

2015 оны 1 дүгээр сарын нэгний байдлаар ОХУ-ын ял эдлүүлэх байгууллагын / Федеральная служба исполнения наказаний-ФСИН/ талаарх статистик үзүүлэлтийг авч үзвэл эрүүгийн ял эдлүүлэх системийн хэмжээнд 671.700 ялтан ял эдэлж байгаагаас 728 засан хүмүүжүүлэх газарт 550.800 ялтан, 129 суурин хэлбэрийн хорих газарт 40.000 ялтан, 6 засан хүмүүжүүлэх газарт бүх насаар хорих ялтай 1897 ялтан, 219 цагдан хорих байр, 108 цагдан хорих байртай ижил дэглэм бүхий байранд 117.400 ялтан, хоригдогч, 8 гянданд 1616 ялтан, 41 хүмүүжлийн хорих газарт 1700 насанд хүрээгүй ялтан, 54.700 эмэгтэй ялтан, хүүхэд асрах байранд эхийн хамт 668 хүүхэд тус тус байршиж байна.<sup>12</sup>

Дээрх тоон үзүүлэлтийг 2010 оны тоон үзүүлэлттэй харьцуулан харвал зөвхөн нийгмээс тусгаарлан хорьж байгаа хүний тоо бараг хоёр зуу шахам мянгаар буурсан байна. 2010 оны 1 дүгээр сарын нэгний байдлаар ОХУ-ын хорих чиг үүрэг бүхий газруудад 864.000 хүн хоригдож байснаас 80 орчим хувь нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт шийтгүүлсэн, шинээр ял шийтгэгсдийн 80 гаруй хувь нь мэргэжлийн болон хөдөлмөрийн дадлага туршлагагүй, нийт ялтны 8 орчим хувь нь ерөнхий боловсрол заавал эзэмших шаардлагатай, 50 орчим хувь нь хоёр буюу түүнээс дээш удаа хорих ялаар шийтгэгдсэн, нийгэмшээгүй, зан харьцааны эвдрэлд орсон ялтны эзлэх жин ихэссэн зэрэг сөрөг нөхцөл байдал бий болсон байсан талаар тухайн үеийн албан ёсны мэдээнд дурджээ.

Түүнчлэн нийт хорих байгууллагын ачаалал тогтоосон хязгаараас 20-40 хувиар давсан, эрүүгийн сөрөг нэр нөлөө бүхий этгээдүүдийн үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул заналхийлэл өссөн, эрүүгийн ял эдлүүлэх албаны бүтэц, тогтолцоог чанаржуулах нийгэм, эдийн засгийн шаардлага бий болсон байдаг. Тиймээс ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албанаас Эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулан ОХУ-ын Засгийн газрын 2010 оны аравдугаар сарын 14-ны өдрийн 1772 дугаар тогтоолоор батлуулан ажиллажээ. Өөрөөр хэлбэл тухайн үеийн ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй асуудал, европын улс орнуудын жишиг туршлагыг нэвтрүүлэх, эрүүгийн ялын үр нөлөөг дээшлүүлэх, ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаа чанаржуулах үүднээс хөгжлийн шинэ чиг хандлага бүхий зорилтот хөтөлбөр боловсруулан үр дүнд хүрч ажилласан байна.

Энэхүү үзэл баримтлалын үндсэн зорилго нь ял эдлүүлэх байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлж, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, засан хүмүүжүүлэх газарт нийгэм сэтгэлзүйн ажлыг шинэ шатанд гаргах, шоронгийн дараах нийгэмд дасан зохицох тогтолцоог хөгжүүлэх замаар рецидив гэмт хэргийг бууруулах, хорих орчныг хүмүүжүүлэх буюу нийгэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх явдал юм хэмээн тодорхойлсон байдаг.<sup>13</sup>

<sup>12</sup> Официальный сайт ФСИН - <http://fsin.su/statistics/2015.02.25/>

<sup>13</sup> Концепция развития уголовно-исполнительной системы до 2020 года. Правительство Российской Федерации. Распоряжение от 14 октября 2010 г. № 1772-р Москва



### Дүгнэлт

Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдалаас дүгнэж үзвэл ялтанд нийгэм, сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх эрх зүйн болон тогтолцоог боловсронгуй болгох, хөгжлийн тодорхой үзэл баримтлал боловсруулан хэрэгжүүлж эрүүгийн ялын бодлогыг нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийг дэмжсэн чиглэлд нийцүүлэн өөрчлөх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Дэлхийн бусад улс орнуудын хорих ял эдлүүлэх ажиллагааны давуу талуудыг өөрийн орны онцлог нөхцөл байдалтай уялдуулан шилжүүлэхдээ ялтныг нийгэмшүүлэх, ял эдлүүлэх орчны стандартыг олон улсын жишигт хүргэх, ялтныг байнгын хөдөлмөр эрхлүүлэх замаар төлөвшүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, суллагдахын өмнө нийгмийн харилцаанд идэвхитэй, зөв байр суурьтай оролцоход бэлтгэх зэрэг нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдол бүхий асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай байна.

ОХУ нь эрүүгийн ял эдлүүлэх тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн, ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр хорих газрын нээлттэй хэлбэрийг бий болгосон, ялтныг засан хүмүүжүүлэхтэй холбогдсон зорилго зорилт, бүхий л үйл ажиллагааг нарийвчилан хуульчилсан байна. Түүнчлэн ОХУ-ын хорих ял эдлүүлэх ажиллагааны хөгжлийн үзэл баримтлалын нэг онцлог хэсэг нь ялтны суллагдсаны дараах нийгэмд дасан зохицох явдлыг хангаж, давтан гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр удаан хугацааны хорих ял эдлээд дуусаж байгаа этгээдэд нийгмийн өөрчлөлтийн тухай бүхий л мэдээллийг багтаасан тусгай дасгалжилт, хөтөлбөр боловсруулан хамруулах, амьдрах орчинтойгоо танилцах боломж олгосон суурин хэлбэрийн хорих газарт шилжүүлэх, ялтныг нийгмийн амьдралд дасгах албаар /probation/ дамжуулан зохих нөхцлийг бүрдүүлэх зэрэг эерэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

### Санал

Дээрх харьцуулсан судалгаа болон манай улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас улбаалан дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хөгжлийн үзэл баримтлалыг сургалт, судалгааны болон төрийн мэргэжлийн байгууллагууд хамтран боловсруулах, Засгын газрын түвшинд батлуулах.

2. Хорих ял эдлүүлэх нөхцөл, орчны стандарт, хорих ангийн төрөл, дэглэмийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх.

3. Ял эдлүүлэх үйл ажиллагаанд ялтны сургалт, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, сургалт нөлөөллийн ажлын шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх.

4. Хорих ял эдлээд суллагдсан хүнийг нийгмийн амьдралд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх хөтөлбөр бүхий төвийг /probation/ байгуулах эрх зүйн орчныг бий болгох.

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилго, хэлбэр, хорих газрын төрөл, дэглэмийн өөрчлөлт, нийгэмшүүлэх ажлын нарийвчлан тусгасан байдлаар шинэчлэн найруулах.

**Эх сурвалжийн жагсаалт**

1. Монгол Улсын Үндсэн хууль 1993 он.
2. Эрүүгийн хууль 2002 он. <http://legalinfo.mn/law/details/50?lawid=50>
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 он.
4. Концепция развития уголовно-исполнительной системы до 2020 года. Правительство Российской Федерации. Распоряжение от 14 октября 2010 г. № 1772-р Москва
5. Распоряжение Правительства РФ от 17 ноября 2008 г. N 1662-р О Концепции долгосрочного социально-экономического развития РФ на период до 2020 года.  
<http://base.garant.ru/194365/#ixzz3TTj6m4kL>
6. Кодексы Российской Федерации. Официальный текст. Уголовный кодекс. Москва 2014
7. Кодексы Российской Федерации. Официальный текст. Уголовно-исполнительный кодекс. Москва 2007 г.
8. А.Лхагва. “МУ-ын Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүй” Улаанбаатар 2012 он.
9. С.Жанцан “МУ-ын Эрүүгийн эрх зүйн онол” Улаанбаатар 2014 он.
10. МГУ им. М.В.Ломоносова “Уголовно-исполнительное право России” Москва 2013 г.
11. Б.Дашзэвэг “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй” 2004 он.
12. ШШГЕГ-ын 2015 оны 3 дугаар сарын албаны статистик мэдээнээс...
13. Официальный сайт ФСИН - <http://fsin.su/>
14. [https://ru.wikipedia.org/wiki/Население\\_России](https://ru.wikipedia.org/wiki/Население_России)
15. Төрийн мэдээлэл. 2012 он. №3
16. <http://www.legalinfo.mn/annex/details/5591?lawid=8722>